

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 5 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 143

Улаанбаатар хот

Г “Жам зам ББСБ” ХХК-ийн зээлийн 7
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг
хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 10.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Жам зам ББСБ” ХХК-ийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. ББСБ-ын гадаад валютын арилжааны үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагааг Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэх болохыг “Жам зам ББСБ” ХХК /Д.Ариунаа/-д анхааруулсугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН